

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шагдар	Дугаар	L316
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Арвайхээр сум
Төрсөн газар	Арвайхээр сум	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уянгын хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХУЯ 027
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 11	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Уянга сумын Уянгын хүрээ буюу Сайн ноёны хүрээ

Жужа: Хэдэн настай лам болсон ?

Өвгөн: 6-тай. 15, 16-тай хүрээ тарсан юм.

Жужа: Аль хүрээнд сууж байсан бэ?

Өвгөн: Уянгын хүрээнд.

Жужа: Аль дацанд сууж байсан бэ?

Өвгөн: Би сургуулийн дацан Жанчивлинд сууж байсан юм.

Энхбаяр: Танай дуган хэдэн ламтай байсан?

Өвгөн: 100 гаруй ламтай.

Энхбаяр: Гол шүтээн?

Өвгөн: Махгал.

Энхбаяр: Цагийн хурал, цогчингоо өдөр бүр хурж байв уу?

Өвгөн: Хруалгүй яахав. Дацан бүр хурна. Молом гэж байдаг шүү дээ. Зуны хурал, намрын хурал, хаврын хурал, өвлийн хурал дөрвөн цагт хурна. Арван сахиусаа хурна.

Энхбаяр: Танай Уянгын хүрээ хэдэн ламтай байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Ээ 2000 нэлээн гарна.

Энхбаяр: Ямар ямар дацантай байсан бэ?

Өвгөн: Сургуулийн дацан, зүүн дацан, баруун талд баруун дуган гэж байсан юм.

Энхбаяр: Танай дуган тоосгон дуган уу, модон дуган уу?

Өвгөн: Янз бүрийн л дуган байсан. Түвд маягийн.

Энхбаяр: Суваргууд олон байв уу?

Өвгөн: Олон байсан. Дөрвөн талдаа суваргатай.

Энхбаяр: Танай Уянгын хүрээнээс гарсан нэр алдартай лам нар?

Өвгөн: Хувилгаан лам, Гачин лам гэж хоёр лам байсан юм. Нэг нь Түвдээс залж ирсэн Гачин лам гэж. Эндхийн Хувилгаан багш гэж байсан юм.

Энхбаяр: Өөр хутагт хувилгаад байсан уу?

Өвгөн: Чойр хамба гэж том лам байсан юм. Гэсгүйтэй, ловон , унзад гэж лам байсан.

Энхбаяр: Дацангуудад хамба гэж байсан юм уу?

Өвгөн: Жижиг дацангуудад хамба гэж байхгүй, ловон байна. Чойр хамбатай.

Энхбаяр: Цам гардаг байсан уу?

Өвгөн: 108 цам харайж байсан юм.

Энхбаяр: Ямар дэгтэй цам байсан юм?

Өвгөн: Арван сахиусны 108 цам харайж байсан.

Энхбаяр: Хэзээ гардаг байсан юм?

Өвгөн: Зуны эхэн сард тэр 108 цам харайна. Цагаан сарын шинийн 16-нд цам харайна.

Энхбаяр: Майдар эргэдэг байсан биз дээ?

Өвгөн: Зуны адаг сарын шинийн 8-нд эргэнэ.

Энхбаяр: Ганжуур эргэдэг байсан уу?

Өвгөн: Эргэлгүй яахав.

Энхбаяр: Зоч лам нар байв уу?

Өвгөн: Сайн мэдэхгүй байна.

Энхбаяр: Хүүчин Уянгын хүрээнээс ондоо том, жижиг сүм дуган байсан уу?

Өвгөн: Байсан байсан. Ойрхон харагдаад байдаг юм. Ламын гэгээний харъяа баруун хүрээ байсан юм.

Энхбаяр: Хоёр хүрээ чинь хоёулаа Ламын гэгээний харъяа байсан юм уу?

Өвгөн: Нэг нь манайх.

Энхбаяр: Тэр Уянгын хүрээнээс хойшоо Олон сүм гээд тэрний талаар сонсож байв уу?

Өвгөн: Тэрний талаар мэдэх юм байхгүй ээ.

Энхбаяр: Одоо энэ Яргайтын аманд Мааньтийн хад гээд байгаа ш дээ. Хужиртад?

Өвгөн: Тийм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энхбаяр: Тэнд сүм байсан уу?

Өвгөн: Дээр нэг сүм байсан гэж ярьдаг юм, би мэдэхгүй.

Энхбаяр: Энэ багш чинь чойрын хүн байж , тийм ээ?

Өвгөн: Тийм.

Энхбаяр: Сэр игчааны хүн үү, гүнчин игчааны хүн үү?

Өвгөн: Мэдэхгүй ээ. Багшийн чинь нэг багш нь Агваан хэн гэлээ , хоёр багштай байсан гэж байгаа юм. Нэг багш нь тэр Арвангуравдугаар далай лам ирж байхад оръё гэтэл оруулахгүй гэж. Тэгэхээр нь дайраад орчихсон юм гэнэ лээ. Чи дуулсан уу?

Энхбаяр: Үгүй ээ, дуулаагүй юм байна. Та Уянгын хүрээнд хэдэн он хүртэл суусан бэ?

Өвгөн: Би нэг арван жил болсон юм даа. Мянга есөн зуун хэдэн онд л байсан байгаа юм даа. 1937 он хүрээ хаагдсан. Миний хувьд хорин хэдэн оны үед л ...

Энхбаяр: Хэдэн настай больж байсан юм?

Өвгөн: Хорин таван оноос л суусан байна даа. Тэгээд л гучин долоон онд л хаасан.

Энхбаяр: Уянгын хүрээний бага байхдаа сууж байсан нэг өдрийн нэг энгийн амьдралын тухай дурсамж байна уу, өглөө босоод л орой тэгдэг гээд л амьдралын хэв маяг байдаг ш дээ?

Өвгөн: Ажил амьдрал, буюнг зээг л үйлдэж явлаа. За тэгээд өглөө босоод нгомоо цээжилнэ ээ, багшда бараалхана. Номыг чинь цээжлэхгүй бол уншуулахгүй ш дээ, нэг цаг, хоёр цаг нүдээд байна. Энэ номыг чинь дан цээжилнэ.

Энхбаяр: Энэ Уянгын хүрээний хойд Уулшхай гээд байна аа. Та тэр доор Тээлийн Уулшхайн талаар сонсож байв уу?

Өвгөн: За би уг нь тэр нутгийн хүн дээ.

Энхбаяр: Та угаасаа энэ сумын хүн?

Өвгөн: Тийм.

Энхбаяр: Танай нэг дүү Нямдаваа гэж лам байна аа, Улаанбаатарт?

Өвгөн: Тийм, одоо 87-той./ нэг зураг үзүүлэв /

Энхбаяр: Та хаана сууж байна вэ?

Өвгөн: Би энд, одоо нүд үзэхгүй ээ. Би 73-тай байсан байгаа юм.

Энхбаяр: Залуу байсан байна ш дээ.

Өвгөн: Энэ 18 жил болж байна.

Энхбаяр: Энэ дөчин лам дотор Цэрэндорж гэж өвгөн байсан биз?

Өвгөн: Чи аль нутгийн хүн бэ?

Энхбаяр: Би Сүхбаатар аймгийн хүн.

Өвгөн: Эндхийн юмыг гадарлаад байх юм аа, бас.

Энхбаяр: Бид нар Цэрэндорж гуайтай уулзсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Аль хэр доройтож?

Энхбаяр: Гайгүй байна лээ, сайхан байна лээ. Таниас арай жоохон муу байгаа юм уу даа.

Өвгөн: Нарийнтээлд Ягаан Даш гэж байгаа. Ингээд тэр бид гурав л үлдсэн. Би тэнд Сүхбаатарт цэрэгт хэдэн жил болж байсан.

Энхбаяр: Хэдэн жил болж байсан, та?

Өвгөн: 6 жил.